



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023 /02/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа
Утас: 70357955 Цахим хаяг: Gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 101

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ГЭР БҮЛИЙН
ОРДОН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон аймгийн "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох хурим найр, тэнгэрлэг гэр бүлийн хүндэтгэл, дархан, уран бэрийн шагнал гардуулах зэрэг үйл ажиллагаа хэвийн явагдсан ч COVID-19 цар тахлын улмаас өмнөх онуудад үйл ажиллагааны орлого тасарч байр ашиглалт болон ажилчдын цалинтай холбоотой үүссэн өр төлбөрүүд төлөгдөөгүй байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл,

мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,967,974.4	42,819,706.46
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,795.49	391,941.68
3	Кассанд байгаа бэлэн мөнгө	34,950.27	3,457.94
4	Төгрөг	34,950.27	3,457.94
5	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,845.22	388,483.74
6	Төгрөг	10,845.22	388,483.74
7	Арилжааны банк дахь харилцах	10,845.22	388,483.74
8	АВЛАГА	10,430,905.66	16,120,720.3
9	Ажиллагчидтай холбогдсон авлага	183,545.4	183,545.4
10	Бусад авлага	10,247,360.26	15,937,174.9
11	Байгууллагаас авах авлага	10,247,360.26	15,937,174.9
12	БАРАА МАТЕРИАЛ	24,491,273.25	26,307,044.48
13	Хангамжийн материал	24,491,273.25	26,307,044.48
14	Бусад хангамжийн материал	24,491,273.25	26,307,044.48
15	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,003,270.09	9,528,886.21
16	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,003,270.09	9,528,886.21
17	Биет хөрөнгө	12,003,270.09	9,528,886.21
18	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,125,299.98	13,125,299.98
19	Хуримтлагдсан элэгдэл	-9,952,036.11	-10,852,592.87
20	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,870,414.83	44,870,414.83
21	Хуримтлагдсан элэгдэл	-36,040,408.61	-37,614,235.73
22	Програм хангамж	1,945,454.55	2,132,454.55
23	Хуримтлагдсан элэгдэл	-1,945,454.55	-2,132,454.55
24	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	46,971,244.49	52,348,592.67
25	НИЙТ ӨР ТӨЛБӨР	67,028,699.23	89,573,182.25
26	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	67,028,699.23	89,573,182.25
27	Өглөг	67,028,699.23	89,573,182.25
28	Бусад өглөг	67,028,699.23	89,573,182.25

29	Байгууллагад төлөх өглөг	44,188,911.6	46,181,868.19
30	Хувь хүмүүст төлөх өглөг		1,530,500
31	Татварын өглөг /ТӨҮГ/	14,156,120.86	22,830,702.16
32	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	7,403,844.77	17,750,289.9
33	Дансны өглөг /ТӨҮГ/	1,279,822	1,279,822
34	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-20,057,454.74	-37,224,589.58
35	Засгийн газрын хувь оролцоо	-20,057,454.74	-37,224,589.58
36	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	43,554,506	43,554,506
37	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	4,512,531.8	4,512,531.8
38	Хуримтлагдсан үр дүн	-71,764,192.54	-88,931,327.38
39	Өмнөх үеийн үр дүн	-51,444,136.73	-71,764,192.54
40	Тайлант үеийн үр дүн	-20,320,055.81	-17,167,134.84
41	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,639,700	3,639,700
42	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	46,971,244.49	52,348,592.67

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	67,179,019.91	77,642,779.27
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,179,019.91	77,642,779.27
3	Нийтлэг татварын бус орлого	67,179,019.91	77,642,779.27
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,130,589.72	30,519,988.3
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,130,589.72	30,519,988.3
6	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	18,048,430.19	47,122,790.97
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	87,499,075.72	94,809,914.11
8	УРСГАЛ ЗАРДАЛ	87,499,075.72	94,809,914.11
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,499,075.72	94,809,914.11
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,175,913.56	92,335,530.23
11	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	85,175,913.56	92,335,530.23
12	Бараа үйлчилгээний бусад зардал	2,323,162.16	2,474,383.88
13	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,323,162.16	2,474,383.88

14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-20,320,055.81	-17,167,134.84
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-20,320,055.81	-17,167,134.84

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-51,444,136.73	262,601.07
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-51,444,136.73	262,601.07
3	Тайлант үеийн үр дүн			-20,320,055.81	-20,320,055.81
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-71,764,192.54	-20,057,454.74
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-71,764,192.54	-20,057,454.74
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-71,764,192.54	-20,057,454.74
7	Тайлант үеийн үр дүн			-17,167,134.84	-17,167,134.84
8	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	48,067,037.8	3,639,700	-88,931,327.38	-37,224,589.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	73,124,719	83,406,664
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,124,719	83,406,664
3	Нийтлэг татварын бус орлого	73,124,719	83,406,664
4	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	73,124,719	83,406,664
5	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,167,828.43	83,060,517.81
6	УРСГАЛ ЗАРДАЛ	73,167,828.43	83,060,517.81
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,167,828.43	83,060,517.81
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,401,342.04	37,102,746.2
9	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	45,401,342.04	37,102,746.2

10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,786,628.96	1,183,959.87
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	4,786,628.96	1,183,959.87
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,246,229.43	9,867,090.63
13	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1,246,229.43	9,867,090.63
14	Хангамж, бараа материалын зардал	15,215,978	16,497,144
15	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	15,215,978	16,497,144
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,517,650	2,494,339.86
17	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		36,500
18	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	6,517,650	2,457,839.86
19	Бараа үйлчилгээний бусад зардал		15,915,237.25
20	Бараа үйлчилгээний бусад зардал		15,915,237.25
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-43,109.43	346,146.19
22	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-43,109.43	346,146.19
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,904.92	45,795.49
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,795.49	391,941.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	96,794,560.02	77,642,779.27
2	Нийт зардал	96,719,706.74	94,809,914.11
3	Татвар ногдох орлого	74,853.28	/17,167,134.84/
4	Татвар 10%	7,485.33	/1,716,713.48/
5	Цэвэр ашиг	67,367.95	/15,450,421.36/
6	Тайлант үеийн ашиг, алдагдал	67,367.95	/15,450,421.36/

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон тайлагналын нийт 35,943.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 35,943.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар нийт 38,665.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 38,665.2 мянган төгрөгийн хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 16,120.7 мянган төгрөгийн авлага, 22,544.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх", гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн авлага өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах.

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлэх 148 талбарын мэдээллээс 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлж, дотоод хяналтыг сайжруулах.

3. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тайлагналын алдаа	5	35,943.3	1	187.0	4	35,756.3	5	35,943.3				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэх 148 талбарын мэдээллээс 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, мөрдөж ажиллах	1	0					1	0
Тайлант хугацаанд 16,120.7 мянган төгрөгийн авлага, 22,544.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.	1	38,665.2					1	38,665.2
Дүн	2	38,665.2					2	38,665.2
Нийт дүн	3	38,665.2					3	38,665.2